

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/108/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2019 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын захирал
бөгөөд

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70352580 Цахим хаяг: bulgan@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: bulgan@audit.gov.mn

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivanaudit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	

2.1. Оршил

Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн дарга Д.Баттулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 01-нээс 2020 оны 03 дугаар сарын 01-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 01-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван аудит ХХК орхон салбарын аудитор Б.Пүрэвсүрэн /Булган аймгийн төрийн аудитын газрын захиалгаар/ хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Далайван аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн 2019 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Үйл ажиллагаандаа дотно харилцаа, итгэлцэлийг бүрдүүлэхэд оршино.

Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол улсын 2019 оны Төсвийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд си ти эс программ хангамж ашигладаг байна.

Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Булган аймгийн Нэгдэсэн эмнэлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,988,891.3 мянган төгрөгөөс тооцон 7,977.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 74,025.4 мянган төгрөгөөр тодорхойлсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 593,473.4 мянган төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа			
Бараа материал	699,885.2	742,102.3	42,217.1
Үндсэн хөрөнгө	5,831,404.3	6,373,765.9	542,361.6
Нийт хөрөнгө	6,531,289.5	7,124,762.9	593,473.4
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,531,289.5	7,124,762.9	593,473.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,531,289.5	7,124,762.9	593,473.4

Авлага дансны үлдэгдэлгүй байгаа нь төсвийн хөрөнгийн зөв зохистой удирдаж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,217.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 855,630.3 мянган төгрөгийн эм боох материал, 13,231.5 мянган төгрөгийн бичиг хэрэг, 38,673.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 49,283.6 мянган төгрөгийн түлш, 23,547.0 мянган төгрөгийн засварын материал, 99,468.5 мянган төгрөгийн хүнсний материал, 34,647.8 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 21,162.2 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал нийт 1,141,587.7 мянган төгрөгийн бараа материал худалдан бэлтгэж 57,650.5 мянган төгрөгийн бараа материал хандив тусламжаар хүлээн авсан байна. Тайлант онд 1,157,229.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 0 мянган төгрөгийн бараа материал акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 542,361.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 1,228,438.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандив тусламжаар, 0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн хүлээн авч, 734,282.5 мянган төгрөгийн элэгдэл тооцосонтой холбоотой.

Хандив тусламжаар 1,228,438.9 мянган төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 48,205.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан бэлтгэсэн байна.

Тайлант онд бие бус хөрөнгөд өөрчлөлт буюу өсөлт, бууралт ороогүй байна.

Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 2019 оны өглөгийн данс эхний үлдэгдэл 0 мянган төгрөг байсан ба үйл ажиллагааны явцад үндсэн үйл ажиллагаатай холбоотой 6,712,693.0 мянган төгрөгийн өглөг үүсэж үүссэн 6,712,693.0 мянган төгрөгийн өглөгийн төлж барагдуулан үлдэгдэлгүй гарч тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд 5,968,161.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 5,966,526.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төвлөрсөн төсвөөс	4,193,686.6	4,191,761.7	1,924.8	100
Орон нутгийн санхүүжилт	59,504.6	59,793.7	289.1	100
Нийгмийн даатгалын сангаас	1,714,970.5	1,714,970.5	0	100
Нийт дүн	5,968,161.7	5,966,526.0	1,635.6	100

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2019 хөтөлбөрт зориулан 5,968,161.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,968,161.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 4,193,686.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 59,504.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,966,526.0 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 60,919.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0 мянган төгрөгийн алдааг залруулж, 0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 9,335.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 51,584.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг өглөө.

Аудитаар дараах 60,919.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 9,335.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Нэгдсэн эмнэлэгийн даргын тушаалаар янз бүрийн баяр ёслол болон ойн арга хэмжээний үйл ажиллагааны бус зардалд их хэмжээний мөнгө зарцуулагдсан байна. Үүнд: хүлээн авалтын хоол 5 630.0 мянган төгрөг, хотоос ирсэн хүмүүсийн буудлын зардалд 2 247.6 мянган төгрөг гэх мэт үйл ажиллагааны бус зардлууд гарсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Байгууллагын дарга нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудын дагуу төсвийг зөв зохистой зарцуулж байхыг албан шаардлагаар хүргүүлээ.

2. Орлого үр дүнгийн тайланд бичиг хэргийн зардлаас 588.0 мянган төгрөгийг ОУЭмч нарын өдрийн цэнгүүний арга хэмжээнд, бичиг хэргийн зардлаас 420 мянган төгрөгийг торгуульд, БҮТЭЗ-ийн зардлаас 450.0 мянган төгрөгийг уралдаан тэмцээний зардалд тус тус зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнах”, Сангийн сайдын 2013 оны 73 тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт журам” -ын 3 дугаар зүйл 3.1.4-д “Цалин хөлс нэмэгдэл, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүлэг болон дангаар зардлын бүлэглэлээс бусад зардлын бүлэг хооронд жилийн батлагдсан төсвийн тухайн зардлын бүлгийн дүнг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэх зохицуулалтын хүсэлт гаргаж болно” гэсэн заалтуудын дагуу шийдвэр гарган зарцуулалтыг хийхийг албан шаардлагаар хүргүүлээ.

Аудитаар илэрсэн 51,584.1 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг шалгаж үзэх.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн данстай холбоотой мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн тайлгансан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийг Булган аймгийн Төрийн аудитын байгууллагад албан бичгээр хүргүүлсэн.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Бэлтгэсэн:

Аудитор

Д.Мягмарсүрэн

Огноо

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Огноо

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор

Д.Анхбаяр

Огноо

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
2	Мөнгөн хөрөнгө	0	8,894,600
37	Нийт хөрөнгө	6,531,289,587.19	7,124,762,924.11
52	Өр төлбөр эзний өмч	6,531,289,587.19	7,124,762,924.11

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны орлого	5,806,165,352.36	7,402,540,842.89
2	Үйл ажиллагааны зардал	5,728,189,731.49	6,809,067,505.97

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны орлогын дүн	5,110,235,719	6,118,360,258
17	Нийт зарлага цэвэр зээл	5,078,493,172	6,061,260,398

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018.12.31	4,055,327,827.6	2,650,105,354.31	-174,143,594.76	6,531,289,587.19
2019.12.31	4,055,327,827.64	2,648,982,957.57	420,452,138.90	7,124,762,924.11

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Нийт зарлага	5,968,161,700	6,107,327,853.71	139,166,153.71	100
Санхүүжилт	5,968,161,700	6,107,327,853.71	139,166,153.71	100